

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/11

Сүмбэр сум

Зохион байгуулалтын нэгжийн индекс
батлах тухай

Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мал эмнэлгийн газрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглах зохион байгуулалтын нэгжийн индексийг хавсралтаар баталсугай.

2. Зохион байгуулалтын нэгжийн индексийг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн албаны дарга /П.Дэлгэрмаа/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОТГОНСҮРЭН

42120006

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны _ р сарын _ ны өдрийн
__дугаар тушаалын ...- р хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
НЭГЖИЙН ИНДЕКС**

№	Албан тушаал	Индекс
1	Мал эмнэлгийн газрын дарга	01
2	Захиргаа, санхүүгийн албаны дарга	02
3	Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга	03
4	Лабораторийн эрхлэгч	04

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 07/2

Сүмбэр сум

Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах
тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2, 71 дүгээр зүйлийн 71.1, 72 дугаар зүйлийн 72.1, 72.4, 72.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үндсэн хөрөнгө болон эд хөрөнгийн эхний хагас жилийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Дэлгэрсүрэн- Мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: О.Пүрэвсамбуу- Өвчний мэдээ, тайлан, цахим бүртгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүн: С.Амарбат- Ариун цэвэр, магадлан шинжилгээний эмч

2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахыг ахлах нягтлан бодогч /Г.Оюунчимэг/, эд хөрөнгийн дотоод тооллогыг зохих хууль, журмын дагуу 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, тооллогын бүртгэлийг баталгаажуулан танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Дэлгэрсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОТГОНСҮРЭН

421200068

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 1/23

Сүмбэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, "Говьсүмбэр аймгийн мал сүрэгт шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторинг тандалт шинжилгээ хийх" 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 2020/09 дугаар бүхий гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторинг тандалт шинжилгээний дээж цуглуулах ажилд зарцуулах шатахууны зардлыг 1 дүгээр хавсралтаар, дээж цуглуулах ажилд оролцох ажилтны томилолтын зардлыг 2 дугаар хавсралтаар, ажил үйлчилгээний хөлс олголтын зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1 565 500 /Нэг сая таван зуун жаран таван мянга таван зуун/ төгрөгийн 1 252 400 /Нэг сая хоёр зуун таван хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас, ажил гүйцэтгэх гэрээний гүйцэтгэл хангагдаж үлдэгдэл санхүүжилт хийгдэхэд 313 100 /Гурван зуун арван гурван мянга нэг зуун/ төгрөгийг тус тус зарцуулахыг ахлах нягтлан бодогч /Т.Оюунчимэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.ОТГОНСҮРЭН

421200074

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 07 сарын 09 ны өдрийн
Ш/Б дугаар тушаалын 7-р хавсралт



**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТЫН
ДАРААХ МОНИТОРИНГ ХИЙХ АЖИЛД ЗАРЦУУЛАХ
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

Дд	Сумын нэр	Туулсан зам	Зарцуулсан шатахуун	100 км-д зарцуулах шатахуун /л/	Нэгж үнэ /₮/	Бүгд үнэ /₮/
1	Баянтал	664.8	113	17	1460	165000
2	Сүмбэр	959	163	17	1460	253000
ДҮН		1623.8	276	-	1460	418000
Хүргэлтийн зардал /Хэрэглэгдэхүүн аймагт хүргэх/		-	-	-	30000	30000
Нийт дүн		-	-	-	-	448000

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 07 сарын 09 ны өдрийн
дугаар тушаалын 02 р хавсралт




**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНЖУУЛАЛТЫН ДАРААХ МОНИТОРИНГ ХИЙХ АЖИЛД ОРОЛЦОХ АЖИЛТНЫ
ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

Дд	Ажилтны нэр	Албан тушаал	Ажилласан хоног	Хоногт олгох /₮/	Бүгд /₮/
1	Ц.Дэлгэрсүрэн	Мал эмнэлгийн лабораторын эрхлэгч	6	26000	156000
2	Б.Ерөөлмаа	Ийлдэс судлалын шинжээч эмч	5	26000	130000
3	Д.Бүрэнжаргал	Лаборант	6	26000	156000
4	Ц.Сувд	Мэргэжилтэн	2	26000	52000
5	Д.Чанцалдулам	Мэргэжилтэн	2	26000	52000
6	Б.Мөнгөнцэцэг	Баянтал сумын МЭТасгийн улсын ахлах байцаагч	3	26000	78000
7	Г.Отгонбаяр	Мал эмнэлгийн жолооч	6	26000	156000
НИЙТ					780000

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 27 сарын 09 ны өдрийн
1/3 дугаар тушаалын 2 р хавсралт

**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ДАРААХ МОНИТОРИНГ
ХИЙХ АЖИЛД ДЭЭЖ ОРОЛЦСОН АЖИЛТНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ОЛГОЛТЫН ЗАРДАЛ**



№	Ажилчдын нэр	Регистрийн дугаар	Дансны дугаар	Дээжийн тоо	Нэг дээжинд олгох хөлс	Бүгд	ХАОАТ /10/	Гарт олгох
1	Ц.Дэлгэрсүрэн	ИЕ90050401	Төрийн банк 310800064586	113	750	84750	8475	76275
2	Б.Ерөөлмаа	Н395122801	Хаан банк 5022896617	113	750	84750	8475	76275
3	Д.Бүрэнжаргал	ЦХ98081311	Хаан банк 5990319396	112	750	84000	8400	75600
2	Б.Мөнгөнцэцэг	ЗЖ88081309	Хаан банк 5994006628	112	750	84000	8400	75600
Нийт				450	-	337500	33750	303750

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны 07 сарын 09 өдөр

Дугаар ᠒/᠒᠒

Сүмбэр сум

Мал угаалгын ажлыг зохион байгуулах
тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3, 21.3.1, 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Малыг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийгдэх мал угаалгын ажлыг 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн технологит хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал угаалгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Мал угаалгын ажлын явц, технологийн мөрдөлтөнд хяналт тавьж зөвлөмж арга зүйгээр хангаж илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллахыг сумдын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нарт, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга /Г.Наранчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОТГОНСҮРЭН

421200070

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 4-р сарын 09-ны өдрийн
дугаар тушаалын 17-р хавсралт



Мал угаалгын ажлын хэсгийн хуваарь

1. Баянтал сум

1. Багийн ахлагч- Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Б.Мөнгөнцэцэг
2. Багийн гишүүн- "Хилийн дэлгэрэх" МЭҮН-ийн малын эмч Л.Сүрэнсугир
3. Багийн гишүүн- МЭГ-ын мэргэжилтэн Д.Чанцалдулам
4. Багийн гишүүн- Жолооч Г.Отгонбаяр

2. Сүмбэр сум 4-р баг

1. Багийн ахлагч- МЭГ-ын мэргэжилтэн Ц.Сувд
2. Багийн гишүүн- "Аргамаг цавьдар" МЭҮН-ийн малын эмч Н.Мягмаржав
3. Багийн гишүүн- "Би Си Ай Эс" МЭҮН-ийн эмч Б.Гэрэлдамба
4. Багийн гишүүн- Жолооч Л.Цагаан

3. Сүмбэр сум 5-р баг

1. Багийн ахлагч- Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Т.Оюунбаатар
2. Багийн гишүүн- "Чойр таван эрдэнэ" МЭҮН-ийн малын эмч Ж.Баярчимэг
3. Багийн гишүүн- МЭГ-ын лабораторийн эрхлэгч Ц.Дэлгэрсүрэн
4. Багийн гишүүн- Жолооч Г.Отгонбаяр

4. Сүмбэр сум 6-р баг

1. Багийн ахлагч- МЭГ-ын лабораторийн ийлдэс судлаач эмч Б.Ерөөлмаа
2. Багийн гишүүн- "Аравжих баян эрдэнэ" МЭҮН-ийн малын эмч Д.Ганбаатар
3. Багийн гишүүн- "Уранхэрлэн" МЭҮН-ийн малын эмч С.Энх-Амгалан
4. Багийн гишүүн- Жолооч Л.Цагаан

5. Шивээговь сум

1. Багийн ахлагч- Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Ш.Буяннэмэх
2. Багийн гишүүн- "Хийморь алтай групп" МЭҮН-ийн малын эмч

А.Цэрэндолгор

3. Багийн гишүүн- МЭГ-ын лабораторийн лаборант Д.Бүрэнжаргал
4. Багийн гишүүн- Жолооч Г.Отгонбаяр



АЖЛЫН УДИРДАМЖ

2020.07.02

Чойр

Угаалгын ажлыг зохион байгуулах тухай

1.Зорилго: Мал, амьтны шимэгчтэх өвчний гаралт, тархалт, өвчлөлийг бууруулах зорилгоор мал амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтоосон хугацаанд үр дүнтэй зохион байгуулах, нийтийн болон мал амьтны эрүүл мэндийг хамгаалахад оршино.

2.Зохион байгуулалт:

1.Шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон бусад зардлыг шийдвэрлэж уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр хамруулах.

2.Сумын хэмжээнд Мал эмнэлгийн тасгийн дарга удирдаж, багийн түвшинд мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлыг төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх. Ажлын хэсэг нь мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлыг технологийн дагуу, төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэх.

3.Хугацаа:

Мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлыг 2020 оны 07 дугаар сараас 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулна.

4.Ажлын хамрах хүрээ:

Угаалганд 428.2 мян.тол мал хамруулна.

№	Сумын нэр	Угаалганд хамрагдах малын тоо	Угаалгын банн
1.	Сүмбэр	309.6	суурин банн-6, зөөврийн банн-1
2.	Баянтал	65.6	суурин банн-1, зөөврийн банн-1
3.	Шивээговь	53.0	суурин банн-1, зөөврийн банн-1
	Нийт	428.2	суурин банн-8, зөөврийн банн-3

5.Хийгдэх ажлын чиглэл:

1. Мал эмнэлгийн нэгжийн эмч нар шимэгчтэх өвчний эпизоотологийн судалгааг үндэслэн мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлж бүх малыг бүрэн хамруулна.

2.Сумын мал эмнэлгийн тасгийн малын эмч, мэргэжилтэн угаалга хийсэн ArcGIS-ийн зураглал гаргаж тэдгээрийг аймгийн Мал эмнэлгийн газарт илгээж нэгтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Мал эмнэлгийн угаалгын ажил үйлчилгээний хөлсөнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 28 тоот тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөнө.

6. Ажлын гүйцэтгэлийг дүгнэх, танилцуулах:

Мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгын ажлын гүйцэтгэлийн нэгдсэн тайланг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн Мал эмнэлгийн газарт ирүүлж, тайлагнана. Ажлын гүйцэтгэл, үр дүнг олон нийтэд мэдээлнэ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠒᠐᠒᠐ оны ᠐7 сарын ᠒᠒ өдөр

Дугаар ᠕/᠒5

Сүмбэр сум

Адууны халдварт өвчнийг тандах шинжилгээг
зохион байгуулах тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчний жагсаалт”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Аймгийн Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр батлах тухай” 31 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/147 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Адууны ям, хачгийн халуун, халдварт цус багасах, нийлүүлгийн өвчний шинжилгээ хийх ажлыг 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд зохион байгуулсугай.

2. Шинжилгээнд дээж цуглуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шинжилгээнд дээж цуглуулах, шинжилгээ хийх ажлын явц, технологийн мөрдөлтөнд хяналт тавьж зөвлөмж арга зүйгээр хангаж илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллахыг сумдын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нарт, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн дотор танилцуулахыг Мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч /Ц.Дэлгэрсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Ч.ОТГОНСҮРЭН

421200083

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 10-р сарын 21-ны өдрийн
№15 дугаар тушаалын 1.-р хавсралт



Шинжилгээнд дээж цуглуулах ажлын хэсгийн хуваарь

1. Баянтал сум /1-р ажлын хэсэг/

1. Багийн ахлагч – МЭГазрын Ийлдэс судлаач Б.Ерөөлмаа
2. Багийн гишүүн- МЭГазрын Лаборант Д.Бүрэнжаргал
3. Багийн гишүүн- Баянтал сумын МЭТасгийн улсын байцаагч Б.Мөнгөнцэцэг
4. Багийн гишүүн-“Хилийн дэлгэрэх” МЭН-ийн эмч Л.Сүрэнсугир
5. Багийн гишүүн- жолооч Г.Отгонбаяр

2. Сүмбэр сум /2-р ажлын хэсэг/

1. Багийн ахлагч – Лабораторийн эрхлэгч Ц.Дэлгэрсүрэн
2. Багийн гишүүн- Сүмбэр сумын МЭТасгийн улсын байцаагч Т.Оюунбаатар
3. Багийн гишүүн-“Би Си Ай Эс” МЭН-ийн эмч Б.Гэрэлдамба
4. Багийн гишүүн- “Аргамгаг цавьдар” МЭҮН-ийн эмч Н.Мягмаржав
5. Багийн гишүүн –“Аравжих баян эрдэнэ” МЭҮН-ийн эмч Д.Ганбаатар
6. Багийн гишүүн –Жолооч Л.Цагаан

3. Сүмбэр сум /3-р ажлын хэсэг/

1. Багийн ахлагч – Зооноз халдварт өвчин харицсан мэргэжилтэн Ц.Сувд
2. Багийн гишүүн- Сүмбэр сумын МЭТасгийн улсын байцаагч Т.Оюунбаатар
3. Багийн гишүүн-“Би Си Ай Эс” МЭН-ийн эмч Б.Гэрэлдамба
4. Багийн гишүүн –“Хөдөлмөрийн оч” МЭҮН-ийн эмч Д.Ундрага
5. Багийн гишүүн –“Чойр таван эрдэнэ” МЭҮН-ийн эмч Ж.Баярчимэг
6. Багийн гишүүн –“Чойр таван эрдэнэ” МЭҮН-ийн эмч Д.Мөнхтуул
7. Багийн гишүүн –Жолооч Л.Цагаан

4. Шивээговь сум /4-р ажлын хэсэг/

1. Багийн ахлагч – МЭГ-ын мэргэжилтэн Д.Чанцалдулам
2. Багийн гишүүн – МЭГ-ын лаборант Д.Бүрэнжаргал
3. Багийн гишүүн- Сүмбэр сумын МЭТасгийн улсын байцаагч Ш.Буяннэмэх
4. Багийн гишүүн-“Хийморь алтай групп” МЭҮН-ийн эмч А.Цэрэндолгор
5. Багийн гишүүн- Жолооч Г.Отгонбаяр

Мал эмнэлгийн газрын даргын
2020 оны 7 р сарын 23 ны өдрийн
18 дугаар тушаалын 2 р хавсралт



АЖЛЫН УДИРДАМЖ

Адууны ям, хачгийн халуун, халдварт цус багасах,
нийлүүлгийн өвчний шинжилгээг зохион байгуулах тухай

Зорилго

Сумын хурдан морь уралддаг, эрлийз адуутай, худалдаа наймаа ихээр хийдэг малчин өрхүүдийн адууг ям, хачгийн халуун, халдварт цус багасах болон нийлүүлгийн өвчний шинжилгээнд хамруулж дээж цуглуулан шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээг авч ажиллах.

Хугацаа

Тус ажлыг 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд зохион байгуулна.

Ажлын хамрах хүрээ

№	Сумын нэр	Өрхийн тоо	Дээжийн тоо	Ажиллах хүний тоо	Ажиллах хоног
1	Баянтал	20	200	5	4
2	Сүмбэр	25	400	10	1-7
3	Шивээговь	20	200	5	4
	Бүгд	65	800	-	-

Хийгдэх ажлын чиглэл

1. Шинжилгээний дээжийг цуглуулахын өмнө батлагдсан удирдамж, холбогдох аргазүйтэй сайтар танилцаж бэлтгэл ажлыг хангаж ажиллах.
2. Шинжилгээнд шаардлагатай бодис, урвалжийн нөөцийг бүрдүүлэх.
3. Дээж бэлтгэх, асуумж судалгаа авах малчин өрхтэй урьдчилан утсаар холбогдож хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллах.
4. Цусны дээжийг гаргацтай дугаарлаж бүртгэлжүүлэн хүйтэн хэлхээний горимд тээвэрлэж аймгийн МЭЛ-д хүргэх.
5. Ямын ХХУ-ын шинжилгээнд 800, Хачгийн халуун /бабезиоз/-ын шинжилгээнд 180, халдварт цус багасах өвчний шинжилгээнд 800, нийлүүлгийн өвчний шинжилгээнд 800 сорьц тус тус хамруулах.
6. Сорьцийг 2 тэнцүү хэсэгт хувааж нэг хэсэгт нь МЭХүрээлэнд харьцуулсан шинжилгээ хийлгэх.
7. Аймгийн МЭЛ-ийн шинжилгээгээр зэрэг дүн үзүүлсэн сорьцыг УМЭАЦТЛ-д баталгаажуулах шинжилгээнд хамруулах.
8. Шинжилгээний үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Ажлын гүйцэтгэлийг дүгнэх, танилцуулах

Тус ажлын явцын мэдээг 7 хоног бүр, нэгдсэн тайланг 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн дотор Мал эмнэлгийн газрын даргад тайлагнана. Ажлийн гүйцэтгэл, үр дүнг олон нийтэд мэдээлнэ.